## “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-ИЙН АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр　　　　Улаанбаатар хот

Авилгатай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

| № | Хийх ажлын агуулга | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Хариуцах нэгж, албан тушаалтан | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.6, 10.2.7, 30.1.3,*<br>- *Авлигын эсрэг хуулийн 5.1.2;* | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, энэ талаархи мэдээллийг компанийн ажилтан, иргэд чөлөөтэй авах нөхцөлийг хангах | жилдээ | ЗЭЗГ | Авилгын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, шаардлагатай мэдээлэл авах боломж нөхцөл компанид бүрдсэн. |
| | | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор компанийн эрх бүхий ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг АТГ-тай хамтран зохион байгуулах | жилдээ | ЗЭЗГ /ЭБАТ/ | Авлигатай тэмцэх газраас 2025 оны 01 дүгээр сард зохион байгуулсан онлайн сургалтад компанийн эрх бүхий албан тушаалтнууд хамрагдсан. |
| | | АТГ-ын зохион байгуулах Авлигын эсрэг үе шаттай сургалтад эрх бүхий албан тушаалтныг хамруулах | жилдээ | ЗЭЗГ /ЭБАТ/ | АТГ-аас зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл, бүрдүүлэлт хариуцсан ажилтанд зориулсан онлайн сургалтад Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/ хариуцсан ажилтан оролцсон. |
| 2 | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, гэрээний төслийг компанийн ажилтнуудад нээлттэй | Компанийн нэгжүүдээс санаачлан боловсруулж байгаа дүрэм журам, удирдлагын шийдвэрийн | жилдээ | БҮХ НЭГЖҮҮД | Шинээр боловсруулж байгаа болон батлагдсан дүрэм журам, гэрээг Эйбл системд байршуулж байгаа. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байлгаж, сонирхогч иргэдтэй харилцан санал солилцох<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.2;*<br>- *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.5.* | төслийг цахим хуудсанд байршуулсан байх | | | |
| | | Компаниас хуулийн этгээдтэй байгуулж буй бүх гэрээнд авлигын эсрэг заалт оруулах. | жилдээ | | Компаниас хуулийн этгээд, иргэнтэй байгуулж байгаа гэрээнд авлигын эсрэг заалт оруулж байгаа. |
| 3 | Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудсаар/<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.4;*<br>- *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл* | 2024 оны төсөв, 2024 оны болон улирал, сарын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг компанийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлэх | Тогтоосон хугацаанд | СБГ | Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.2 тус тус заалтын дагуу сар бүрийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн санхүүгийн тайланг ААНОАТ- ын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацаанд нь оруулан ажилласан. |
| 4 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.5;*<br>- *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл;* | Сул орон тооны зарыг цахим хуудсандаа тухай бүр шинэчлэн байршуулах | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | Сул орон тооны зарыг тухай бүрт холбогдох сайтууд дээр шинэчлэн байршуулсан. |
| | | Сонгон шалгаруулалт явуулах талаар цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | Компанийн вэбсайт, facebook групп, zangia.mn сайт дээр нээлттэй ажлын байрны зарыг тогтмол байршуулан ажилласан. |
| 5 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | 1. Гүйцэтгэх захирлын 2025 оны А/24 тоот тушаалаар Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 309 төсөл арга хэмжээ 88,4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.4;*<br>- *Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл*<br>- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47.4, 48.5* | | | | тэрбум төгрөг төлөвлөн батлуулж цахим систем /tender.gov.mn/-д байршуулсан.<br>2. Гүйцэтгэх захирлын 2025 оны А/121 тоот тушаалаар 2025 оны худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөг 127 төсөл арга хэмжээ 10,5 тэрбум төгрөг төлөвлөж батлуулж цахим систем /tender.gov.mn/-д байршуулсан. |
| | | Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | Нээлттэй болон харьцуулалтын аргаар 23 тендер шалгаруулалт зарласан бөгөөд үүнээс гэрээ байгуулсан 4, тендер шалгаруулалтын урилгыг зарласан 15, 2 тендер хэмнэгдсэн, 2 амжилтгүй болсон үзүүлэлтийг tender.gov.mn цахим системд байршуулсан болно. |
| | | Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг холбогдох этгээдэд мэдээлэх | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот албан бичгийн дагуу худалдан авах ажиллагааг түр зогсоосон.<br>Нээлттэй болон харьцуулалтын аргаар 23 тендер шалгаруулалт төлөвлөсөн бөгөөд үүнээс гэрээ байгуулсан 1, гэрээ байгуулахаар мэдэгдэл хүргүүлсэн 5, тендер шалгаруулалтын урилгыг зарласан 15, 2 тендер хэмнэгдсэн байна.<br><br>- Шууд худалдан авалтаар 104 төсөл арга хэмжээ 1,3 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 34 төсөл арга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээ 522,7 сая төгргийн гүйцэтгэлтэй. |
| | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | Тухай бүр | ЗЭЗГ /ЗХ/ | 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 5 төрийн бус байгууллагын 5 хараат бус гишүүнийг үнэлгээний хорооны гишүүдээр ажиллуулсан. |
| 6 | Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.9, 6.8, 6.1.6;*<br>- *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 7.2.6, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл;* | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан иргэнийг эрх бүхий албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэж байх | жилдээ | ЗЭЗГ /ЗХ/ | 2025 онд нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 22 этгээдийн ХАСУМ-ийг АТГ-аар хянуулж, ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан ажилтныг эрх бүхий албан тушаалтнаар томилсон. |
| | | Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх | жилдээ | ЗЭЗГ /ЗХ/ | Компанийн ёс зүйн дүрэмд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалтыг тусгаж өгсөн бөгөөд дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. |
| | | Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх | жилдээ | ЗЭЗГ /ЗХ/ | Тогтмол тусгай дугаар ажиллуулж, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| | | Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх | жилдээ | ЗЭЗГ /ЭБАТ/ | Тайлангийн хугацаанд илэрсэн зөрчил байхгүй. |
| | | Компанийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, | жилдээ | ЗЭЗГ ХШУДАА | Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 01-+ний өдрийн А/148 дугаар тушаалаар Ажилтнуудын сарын ажлын үр |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шударга болгох чиглэлээр арга хэмжээ авах | | | дүнг үнэлэх нэмэгдэл олгох журмыг шинэчлэн баталж ажилтнуудын үйл ажиллагааг үнэн зөв шударга үнэлэх нөхцлийг бүрдүүлсэн. |
| 7 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах<br><br>***Эрх зүйн үндэслэл:***<br>- *Авлигын эсрэг хуулийн 6.1.12;*<br>- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.1* | Эрх бүхий албан тушаалтан томилогдсоноос хойш хуульд заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авах, мэдүүлгээ хугацаанд нь гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох | жилдээ | ЗЭЗГ /ЭБАТ/ | Тайлангийн хугацаанд 27 албан тушаалтны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж, шинээр томилогдсон 13 албан тушаалтны ХАСХОМ-ийг гаргуулан баталгаажуулсан. |
| | | Удирдлагын шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулахын өмнө эрх бүхий албан тушаалтнаар тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвшүүлэх | жилдээ | БҮХ НЭГЖ | Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолоор "Нийтийн албан тушаалтны ашиг, сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбар"-ын маягт шинэчлэн батлагдсан бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн, зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдэгдэл, тайлбар гаргадаг болсон. |
| 8 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх<br><br>***Эрх зүйн үндэслэл:*** | Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | Тухай бүр | ЗЭЗГ /ЭБАТ/ | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг хянасан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж байна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | - *Авлигын эсрэг хуулийн 6.6, 6.7, 18.4.2, 29.4;*<br>- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2* | АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар ирүүлсэн мэдэгдлийн дагуу холбогдох арга хэмжээ авах | Тухай бүр | ЗЭЗГ /ЭБАТ/ | АТГ-аас 2025 онд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах талаар мэдэгдэл, албан бичиг ирүүлээгүй байна. |
| | | АТГ-аас зөрчил арилгуулах, хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн дагуу холбогдох арга хэмжээ авах | Тухай бүр | ЗЭЗГ /ЭБАТ/ | АТГ-аас 2025 онд зөрчил арилгуулах, араг хэмжээ авах талаар мэдэгдэл, албан бичиг ирүүлээгүй байна. |
| | | Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох | Тухай бүр | ЗЭЗГ | Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмуудад шинжилгээ хийхэд авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байж болзошгүй дүрэм журам илрээгүй. |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА Э.ТҮМЭНЖАРГАЛ

ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Ж.БАТТУЛГА

ХУУЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТНАЙРАМДАЛ

НЭГТГЭСЭН:

ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН АЖИЛЛГААНЫ ХЭЛТСИЙН ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН В.ЛХАГВАДОРЖ